

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21².4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн “Хүүхдийн төлөө сангийн дүрэм, сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” 261 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.24-т заасан “Хүүхдийн төлөө сан” (цаашид “сан” гэх)-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Сангийн үйл ажиллагаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журамд нийцсэн байна.

1.3. Сан нь Төрийн санд харилцах данстай байна.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сангийн удирдлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.

2.2. Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, мөнгөн бус хандивын хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулах, сангаас санхүүжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэн, сонгон шалгаруулж шийдвэрлэх, чиг үүрэг бүхий Удирдах хороо (цаашид “Хороо” гэх) ажиллана.

2.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Хороо байгуулах шийдвэр гаргаж, бүрэлдэхүүнийг батална. Хороо нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

2.3.1. Боловсрол, шинжлэх ухааны яамны бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгжийн дарга;

2.3.2. Соёлын яамны соёл, урлагийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга;

2.3.3. Зам, тээврийн хөгжлийн яамны авто замын бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга;

2.3.4. Барилга, хот байгуулалтын яамны барилгын зураг төслийн асуудал хариуцсан нэгжийн дарга;

2.3.5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүүхдийн асуудал хариуцсан нэгжийн дарга;

2.3.6. Биеийн тамир, спортын үндэсний хорооны төлөөлөл;

2.3.7. Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл;

2.3.8. хүүхдийн төлөөлөл;

2.3.9. бусад.

2.4. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд гишүүдийн 75-аас дээш хувь оролцооноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Шаардлагатай тохиолдолд хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2.5. Удирдах хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадахгүйд хүрвэл энэ тухайгаа Удирдах хорооны нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх бөгөөд бичгээр саналаа өгч болно.

2.6. Хорооны хуралдааны шийдвэр нь хурлын тэмдэглэл байх бөгөөд Удирдах хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.7. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Хорооны дарга байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

2.8. Хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.8.1. сангийн үйл ажиллагаа болон сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн шийдвэрлүүлэх;

2.8.2. сангийн хөрөнгийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

2.8.3. сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах;

2.8.4. сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнгийн талаарх тайланг хэлэлцэн дүгнэлт гаргах;

2.8.5. сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг даалгавар өгөх;

2.8.6. олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

2.8.7. санд хөрөнгө хандивлаж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, алдаршуулах, сурталчлах;

2.8.8. сангийн хөрөнгөөс тухайн жилд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт болон шагнал урамшуулал, дэмжлэгт зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг хэлэлцэн шийдвэрлэж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд танилцуулж батлуулах;

2.8.9. хорооны хурлыг хагас, бүтэн жилд, шаардлагатай тохиолдолд Хорооны даргын товлосон хугацаанд зохион байгуулна;

2.9. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Хүүхдийн төлөө сангийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

2.10. Ажлын алба нь сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.10.1. тухай жилийн хүүхдийн хөгжлийн төлөө бүтээн байгуулалтын жагсаалт гаргаж, эрэмбэлэх, арга хэмжээний санал, хүсэлтийг энэ журмын 5.2.1-д заасан хугацаанд хүлээн авах;

2.10.2. хорооны хурлын зохион байгуулалтыг хангаж, сангаас санхүүжүүлэх бүтээн байгуулалтын арга хэмжээний саналыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

2.10.3. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын санхүүжилтийг олгох;

2.10.4. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн шийдвэрээр шинэ бүтээн байгуулалт хийх, арга хэмжээнд сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх тохиолдолд санал бэлтгэж шийдвэрлүүлэх, холбогдох байгууллагатай хамтран Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах;

2.10.5. тухайн жилд урамшуулал, дэмжлэг үзүүлэх шаардагдах төсвийн саналыг боловсруулж, хороогоор хэлэлцүүлэх, энэ журмын 6, 7-д заасны дагуу дэмжлэг урамшууллыг олгох;

2.10.6. шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах, хөндлөнгийн дүгнэлт гаргуулах асуудлаар гэрээ хэлцэл хийх;

2.10.7. сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээ, хөрөнгийн зарцуулалтын талаар олон нийтэд мэдээлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, сангийн мэдээллийн цахим хуудас ажиллуулах;

2.10.8. баталсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих, сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг энэ журмын 8.4, 8.5-д заасны дагуу, тайлагнах;

Гурав. Сангийн эх үүсвэр бүрдүүлэх

3.1. Сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1.1, 6.1.2, 21².2.1, 21².2.2, 21².2.3-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг сангийн дансанд бэлэн бус хэлбэрээр төвлөрүүлнэ.

3.3. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс мөнгөн бусаар ирүүлсэн хандив, тусламжийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаалж, санд бэлэн бусаар төвлөрүүлнэ.

3.4. Дуудлага худалдааг ажлын алба хэзээ, хаана, хэрхэн зохион байгуулахыг хорооны хурлаар шийдвэрлэнэ.

3.5. Сангийн эх үүсвэр төвлөрүүлэхтэй холбогдолтой урлаг, спортын үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулж, хандив тусламж төвлөрүүлэх тохиолдолд заавал сангийн дансаар хүлээн авна.

Дөрөв. Сангийн зарцуулалт

4.1. Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21².3-д заасан дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

4.1.1. хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих;

4.1.2. олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;

4.1.3. олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх;

4.2. Сангийн хөрөнгийг зарцуулахдаа хорооны даргын шийдвэрийг үндэслэн нарийн бичгийн дарга сангийн зарцуулалтын гүйлгээг зохих журмын дагуу хийнэ.

Тав. Сангийн хөрөнгөөр хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих

5.1. Санхүүжилтээр дэмжих бүтээн байгуулалтад тавигдах шаардлага

5.1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21^{2.3} д заасны дагуу хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт байх;

5.1.2. Санхүүжүүлэх арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт ирүүлсэн байх;

5.1.3. хүүхдэд үзүүлэх үйлчилгээний тулгамдсан хэрэгцээ шаардлага, хөгжлийн үйлчилгээний чиглэлийг тодорхойлсон байх;

5.1.4. байгуулагдсаны дараа үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хүний нөөц, санхүүгийн зардлын эх үүсвэр тодорхойлогдсон байх;

5.1.5. байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх;

5.1.6. үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааврыг хангасан байх;

5.2. Иргэд, олон нийтийн санал хүсэлтийн дагуу Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, хорооноос шинээр хүүхдийн төлөө бүтээн байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж болно. Ийм тохиолдолд барилгын зураг, төслийн санхүүжилтийг сангаас санхүүжүүлнэ.

5.3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний санал хүлээн авах, сонгон шалгаруулах

5.3.1. сангаас хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын санхүүжилтийн дэмжлэг хүссэн этгээд нь энэ журмын 5.1-д заасан шаардлага хангасан материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 15-аас 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр ирүүлнэ.

5.3.2. энэ журмын 5.2.1-д заасан хугацаанаас бусад үед арга хэмжээний санал хүлээн авахгүй.

5.3.3. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн арга хэмжээтэй холбогдуулж нэмэлт мэдээлэл авч болно.

5.3.4. санал ирүүлсэн иргэн, хуулийн этгээдээр хорооны хуралдаанд танилцуулга хийлгэж болно.

5.3.5. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, хорооны гишүүдийн санал, шийдвэрийг үндэслэн шинэ бүтээн байгуулалтыг арга хэмжээг хэрэгжүүлж болно.

5.3.6. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.2-т заасан шинэ бүтээн байгуулалтын саналыг энэ журмын 5.1-д заасан шаардлагад нийцүүлэн бэлтгэж, хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.3.7. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага арга хэмжээний санал хүлээн авах хугацаа дууссан өдрөөс хойш 14 хоногт багтаан хорооны хуралдааныг зохион байгуулна.

5.3.8. хороо нь санхүүжилтийн дэмжлэг авах бүтээн байгуулалтыг сонгон шалгаруулж, шийдвэрийг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулна.

5.3.9. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 5.3.8-д заасан шийдвэрийг үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.1-д нийцүүлэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргана.

5.3.10. хорооны дүгнэлт, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр нь тухайн төсвийн жилдээ хүчинтэй байна.

5.3.11. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.2-т заасан шинэ бүтээн байгуулалтын ажлыг холбогдох байгууллагатай хамтран Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажил гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжилтийг хариуцна.

5.3.12. арга хэмжээг хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд нь гүйцэтгэсэн ажлын төсвийн зарцуулалт, хүрсэн үр дүн, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, гүйцэтгэлийн нэгдсэн тайланг гэрээнд заасан хугацаанд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Зургаа. Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах

6.1. Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, олимпиадад оролцож амжилт гаргасан хүүхдийг урамшуулах, уралдаан тэмцээний жагсаалт болон урамшууллын хувь хэмжээг энэ журмын хавсралтаар батална.

6.1.1. Энэ журмын хавсралтаар баталсан соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, олимпиадын жагсаалт нь Засгийн газраас баталсан Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, олон улсын хэмжээнд зохиогддог өсвөрийн уран бүтээлчдийн их наадам зэрэг уралдаан тэмцээн наадмын жагсаалттай давхцаагүй байна.

6.1.2. багийн спортын төрлөөр медаль хүртсэн тамирчин тус бүрийн тэмцээний оролцооны статистикийг харгалзан мөнгөн шагналыг олгоно. Нэг тамирчинд олгох урамшууллын мөнгөн дүнгээс 50 хүртэл хувийн оролцоог хангасан тамирчинд 50 хувь, 50-иас дээш хувийн оролцоотой тамирчинд 100 хувиар тооцож олгоно.

6.2. Мөнгөн шагнал урамшуулал олгох болзол хангасан хүүхдийн харьяалах байгууллага, мэргэжлийн холбоо нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараах материалыг бүрдүүлэн тэмцээн дууссанаас хойш 14 хоногийн дотор ирүүлнэ.

6.2.1. урамшуулал авах хүсэлт;

6.2.2. төрсний гэрчилгээ, гадаад паспортын хуулбар;

6.2.3. дипломын нотариатаар батлуулсан хуулбар, тэмцээн, наадамд амжилт гаргасныг нотолсон албан ёсны протоколыг байршуулсан цахим хаяг;

6.2.4. мөнгөн урамшууллыг шилжүүлэх банкны нэр, дансны дугаар, хүлээн авагчийн нэр, регистрийн дугаар;

6.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн хүсэлтийг хорооны даргад танилцуулж, мөнгөн урамшууллыг тухайн улиралд багтаан олгоно.

Долоо. Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх

7.1. Энэ журмын хавсралтаар баталсан жагсаалт болон Засгийн газраас баталсан Олон улсын олимпийн хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, олон улсын хэмжээнд зохиогддог өсвөрийн уран бүтээлчдийн их наадам зэрэг олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хийж байгаа болон болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг үзүүлнэ.

7.2. Дэмжлэг нь дараах төрөлтэй байна.

- 7.2.1. бэлтгэл сургуулилт хийх заал, байрны түрээсийн зардлын;
- 7.2.2. шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлын;
- 7.2.3. замын зардлын;
- 7.2.4. тэмцээний хураамжийн;
- 7.2.5. хувцас хэрэгслийн;
- 7.2.6. бусад

7.3. Дэмжлэгийг дараах хувь, хэмжээгээр тооцож олгоно.

- 7.4.1. хүүхдийн тэмцээний хураамж, замын зардлын 100 хувь;
- 7.4.2. бусад төрлийн дэмжлэгт нэг хүүхдэд оногдох нийт зардлын дээд хэмжээ 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй байх;

7.4. Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн харьяалах байгууллага, мэргэжлийн холбоо нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараах материалыг бүрдүүлэн тэмцээн зохион байгуулагдах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.

- 7.4.1. дэмжлэг авах хүсэлт;
- 7.4.2. уралдаан тэмцээний албан ёсны урилга, заавар, тухайн тэмцээний мэдээллийг байршуулсан албан ёсны цахим хаяг;
- 7.4.3. хөгжлийн бэрхшээлийн талаар эмчийн магадалгаа;
- 7.4.4. оролцогч хүүхдийн төрсний гэрчилгээ, гадаад паспортын хуулбар;
- 7.4.5. шаардагдах зардлын тооцоо /захиалгын хуудас, нэхэмжлэх, гэрээ/

7.5. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дэмжлэг хүссэн хүсэлтийн бүрдэл, үндэслэл нотолгоог нягтлан шалгаж, шаардлага хангасан хүсэлтийг 14 хоногийн дотор хорооны даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

7.6. Шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногт багтаан дэмжлэгийг олгоно.

Найм. Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

8.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтад хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

8.2. Сангийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон тохиолдолд гэрээг цуцалж, үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй бөгөөд зориулалтын бусаар зарцуулсан хөрөнгийг эргэн төлүүлэх арга хэмжээ авна.

8.3. Төрийн аудитын байгууллага сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

8.4. Хүүхдийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сангийн хөрөнгийн зарцуулалтын жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлт, тайлан гарснаас хойш 14 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

8.5. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гарган хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

8.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд танилцуулна.

8.7. Сангийн орлого, зарлагыг албан ёсны цахим хуудсаар дамжуулж, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.

8.8. Сангийн цахим хуудсаар дамжуулж сангаас урамшуулал, дэмжлэг авсан хүүхэд, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

8.9. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

Ес. Бусад

9.1. Сангийн талаар дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

9.1.1. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөлгүйгээр иргэн, хуулийн этгээдээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа явуулах;

9.1.2. сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, баталгаа гаргах;

9.1.3. сангийн хөрөнгөнөөс аливаа татаас, тус журмын 6.1, 7.1-т зааснаас бусад дэмжлэг, урамшуулал, тусламж, хандив олгох;

9.1.4. Хууль тогтоомжид заасан бусад.

Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах,
түүнд хяналт тавих журмын хавсралт

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГААС ОЛОН УЛС, ТИВ, ДЭЛХИЙН СОЁЛ,
УРЛАГ, СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОЖ АМЖИЛТ ГАРГАСАН
ХҮҮХДЭД НЭГ УДАА ОЛГОХ МӨНГӨН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ

д	Ангилал	Төрөл	Хүртсэн медаль /эзэлсэн байр/	Урамшууллын хэмжээ (мян.төг)
СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭН				
1.	Азийн аварга	Спортын бүх төрөл	Алт	5.000.0
			Мөнгө	4.000.0
			Хүрэл	3.000.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно
2.	Азийн аваргын Цуврал тэмцээн /гран-при/	Спортын бүх төрөл	Алт	3.000.0
			Мөнгө	2.000.0
			Хүрэл	1.000.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно
3.	Ази тивийн шатрын аварга шалгаруулах тэмцээн	Шатрын сурагчдын Ази тивийн шалгаруулах тэмцээн/ жилд 1 удаа/	Алт	3.000.0
			Мөнгө	2.000.0
			Хүрэл	1.000.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно
4.		Шатрын Зүүн Азийн аврага шалгаруулах тэмцээн /жилд нэг удаа/	Алт	3.000.0
			Мөнгө	2.000.0
			Хүрэл	1.000.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно
5.	Дэлхийн шатрын олимпиад	Дэлхийн шатрын олимпиад /16 доош насны ангилалтай баг 5 хүний бүрэлдэхүүнтэй/	Алт	5.000.0
			Мөнгө	3.000.0
			Хүрэл	2.000.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр

6	Азийн аварга, цуврал тэмцээний багийн спортын төрөл	Черлидинг	Алт	журмын 6.1.2-т
			Мөнгө	заасан хувь
			Хүрэл	хэмжээгээр тооцно
		Сагсан бөмбөг 3x3,5x5	Алт	журмын 6.1.2-т
			Мөнгө	заасан хувь
			Хүрэл	хэмжээгээр тооцно
		Волейбол	Алт	журмын 6.1.2-т
			Мөнгө	заасан хувь
			Хүрэл	хэмжээгээр тооцно
		Гандбол	Алт	журмын 6.1.2-т
			Мөнгө	заасан хувь
			Хүрэл	хэмжээгээр тооцно
		Хөлбөмбөг	Алт	журмын 6.1.2-т
			Мөнгө	заасан хувь
			Хүрэл	хэмжээгээр тооцно
		Регби	Алт	журмын 6.1.2-т
			Мөнгө	заасан хувь
			Хүрэл	хэмжээгээр тооцно
Крикет	Алт	журмын 6.1.2-т		
	Мөнгө	заасан хувь		
	Хүрэл	хэмжээгээр тооцно		

СОЁЛ, УРЛАГИЙН УРАЛДААН ТЭМЦЭЭН

1.		БНСУ-д зохион байгуулагддаг Зүүн хойд засаг захиргаадын “NEAR” олон улсын хүүхдийн уран зургийн уралдаан /жил бүр/	Алт	1.000.0
			Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
		БНХАУ-дад зохион байгуулагддаг “Цайны зам” Олон улсын Уран бичлэгийн уралдаан	Алт	1.000.0
			Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
2.	Хөгжим	Итали, Римини “Олон улсын хөгжимчдийн уралдаан	Алт	1.500.0
			Мөнгө	1.000.0
			Хүрэл	500.0
		Итал улс “Аргентогийн нэрэмжит өсвөрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан	Алт	1.000.0
			Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
Бүгд Найрамдах Чех улсад зохиогддог “Усти Над Орли “	Алт	800.0		
	Мөнгө	500.0		

		Касианы нэрэмжит хийл хөгжимчдийн уралдаан	Хүрэл	300.0
			хамтлаг	1.500.0
			Алт	1.000.0
		Америкийн Нэгдсэн Улс, Нью-Йорк “Карнеги холл”-д тоглох эрхийн төлөөх уралдаан /жил бүр/	Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
			Алт	1.000.0
		Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод зохиогддог “Фламе” олон улсын уралдаан /жил бүр/	Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
			Алт	1.000.0
		Итали улсын “Барток-Кабалевский-Прокофьев” –н нэрэмжит төгөлдөр хуурчдын уралдаан/жил бүр/	Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
			Алт	1.000.0
Бүгд Найрамдах Чех улсад зохиогддог Б.Сметана нэрэмжит өсвөрийн төгөлдөр хуурчдын уралдаан	Мөнгө	800.0		
	Хүрэл	500.0		
	Алт	1.000.0		
5.	Олон улсын циркийн тэмцээн	Оросын Холбоон Улсын Никулиний циркээс зохион байгуулдаг Олон улсын циркчдийн тэмцээн /хүүхдийн төрөл жил бүр/	Алт	1.000.0
			Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
		Австралийн олон улсын циркчдийн фестиваль /хүүхдийн төрөл жил бүр/	Баг	2.000.0
			Алт	1.000.0
			Мөнгө	800.0
			Хүрэл	500.0
			Баг	1.500.0-2.500.0
ОЮУН УХААНЫ СПОРТЫН ТЭМЦЭЭН				
1.	Ой тогтоолтын олон улсын аварга шалгаруулах тэмцээн	Ой тогтоолтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /2жилд 1 удаа/	Алт	2.000.0
			Мөнгө	1.500.0
			Хүрэл	1.000.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно
			Алт	3.000.0
			Мөнгө	2.000.0
		"Memoriad" World Mental Olympics буюу Оюуны олимп /4 жилд 1 удаа/	Хүрэл	1.500.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно
			Алт	1.500.0
		Ой тогтоолтын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн жилд 1 удаа /	Мөнгө	1.000.0
			Хүрэл	800.0
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр
Алт	1.500.0			

			Алт	2.000.0	
			Мөнгө	1.500.0	
			Хүрэл	1.000.0	
		Ой тогтоолтын нээлттэй олон улсын тэмцээн / жилд 1 удаа/	Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно	
2.	Спорт өрөлтийн олон улсын аварга шалгаруулах тэмцээн	Олон Улсын Спорт өрөлтийн нээлттэй тэмцээн /жилд 1 удаа/	Алт	2.000.0	
			Мөнгө	1.500.0	
			Хүрэл	1.000.0	
		Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно		
		Дэлхийн спорт өрөлтийн холбооны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн /жилд 1 удаа/	Дэлхийн спорт өрөлтийн холбооны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /жилд 1 удаа/	Алт	2.000.0
				Мөнгө	1.500.0
	Хүрэл			1.000.0	
	Баг		журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно		
	Рубик шооны дэлхийн аврага шалгаруулах тэмцээн /жилд 1 удаа/		Рубик шооны Азийн аварга / жилд 1 удаа/	Алт	1.500.0
				Мөнгө	1.000.0
		Хүрэл		800.0	
		Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно		
3.		Рубик шооны олон улсын аварга шалгаруулах тэмцээн	Алт	1.000.0	
			Мөнгө	800.0	
	Хүрэл		500.0		
	Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно			
	4.	Соробан сампин, цээж тоолол	UCMAS олон улсын уралдаан соробан сампин, цээж тооллын олон улсын тэмцээн /жилд 4 удаа 10 ангилалтай/	Алт	1.000.0
				Мөнгө	800.0
Хүрэл				500.0	
Баг				журмын 6.1.2-т	

				заасан хувь хэмжээгээр тооцно	
5.	Түргэн бодолт	Түргэн бодолтын олон улсын аварга шалгаруулах тэмцээн	Алт	1.000.0	
			Мөнгө	800.0	
			Хүрэл	500.0	
			Баг	журмын 6.1.2-т заасан хувь хэмжээгээр тооцно	
ОЛОН УЛСЫН ОЛИМПИАД					
1.	Олон улсын олимпиад	Математик	Алт	3.000.0	
2.			Биологи	Мөнгө	2.000.0
				Хүрэл	1.500.0
		Алт		3.000.0	
3.		Газар зүй	Мөнгө	2.000.0	
			Хүрэл	1.500.0	
			Алт	3.000.0	
4.		Физик	Мөнгө	2.000.0	
			Хүрэл	1.500.0	
			Алт	3.000.0	
5.		Мэдээлэл зүй	Мөнгө	2.000.0	
			Хүрэл	1.500.0	
			Алт	3.000.0	
6.		Хими	Мөнгө	2.000.0	
			Хүрэл	1.500.0	
			Алт	3.000.0	

---oOo---